



62

УВС АЙМАГ  
ДАВСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/08

Зүүнхөвөө

Орон тооны бус зөвлөл байгуулах  
тухай

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Б.Анхбаяр - Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга: П.Уранчимэг - Төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүд: Г.Дулмаа /сумын Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо

П.Мандахбаяр /1-р багийн иргэний төлөөлөл /

С.Гунгаажанцан /2-р багийн иргэний төлөөлөл /

С.Цэдэндорж /3-р багийн иргэний төлөөлөл /

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд байнгын хяналт тавьж “ Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5.3 дахь заалтыг хэрэгжүүлж, дүн гүйцэтгэлийн тайланг иргэдэд мэдээлж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг зөвлөл, дарга /Б.Анхбаяр/ –д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



ЦАМАРТҮВШИН

Doc.togtoolA4

9521530021